

**КОВИД-19 ХАЛДВАРЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР УЛСЫН ОНЦГОЙ КОМИССООС  
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

**1. Ерөнхий нөхцөл байдлын талаар:**

2020 оны 11 сарын 17-ны өдрийн байдлаар КОВИД-19 халдварын цар тахал 216 улсын 55,354,764 хүн халдварлаж, 1,332,406 хүн нас барж, 38,500,557 эдгэрчээ.

11 дүгээр сарын 15-ны байдлаар 44 улс дотоодын хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож, 90 улс олон нийтийн үйлчилгээний газар, цуглаан, сургуулийн үйл ажиллагааг хязгаарлаж, 73 улс хилээ хэсэгчлэн болон бүрэн хааж, хөл хорио тогтоон урьдчилан сэргийлэх, халдварын голомтыг устгах, тархалтыг хязгаарлах арга хэмжээг авч байна.

2020 оны 11-р сарын 10-17-ны өдрийн хооронд PCR 4237, түргэвчилсэн оношлуураар 23528 иргэн шинжилгээнд хамрагдснаас батлагдсан тохиолдол 29 байна. Нийт батлагдсан тоо 455 байгаагаас 341 хүнийг буюу 74.9 хувийг нь эмчлээд байгаа ба одоо ХӨСҮТ-д 114 хүн ковид оношоор эмчлүүлж байна.

2020 оны 11-р сарын 10-17-ны өдрүүдэд КОВИД-19 халдварын тохиолдол бүртгэгдсэн байдлаас үзэхэд:

- Дотооддоо алдсан: Улаанбаатар хотод – 14, Сэлэнгэ аймагт – 11, Дархан-Уул аймагт – 4 тус тус байна.
- Зөвөөрлөгдөн орж ирсэн 8 тохиолдол бүртгэгджээ.

Байршил	Нийт дотооддоо илэрсэн тохиолдлын тоо	PCR шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо	Түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо	Түргэвчилсэн оношлуураар шинжилгээний сорьц авах цэгийн тоо
Улаанбаатар хот	14	3,240	10,241	51
Сэлэнгэ аймаг	11	444	2797	25
Дархан-Уул аймаг	4	553	10,490	14
Бүгд	29	4237	23528	90

2020 оны 11-р сарын 10-ны өдөр КОВИД-19 халдварын дотоодод илэрсэн анхны тохиолдол Улаанбаатар хотод бүртгэгдсэн тул Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоолоор 2020 оны 11-р сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 11-р сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн.

2020 оны 11-р сарын 10-15-ны өдрүүдэд дотоодод илэрсэн тохиолдлууд Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад бүртгэгдэж, тоо нь нэмэгдсэн тул 11-р сарын 15-ны өдөр болсон УОК-ын 35-р хуралдаанаар гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацааг 2020 оны 12-р сарын 01-ний өдрийг хүртэл сунган шийдвэрлэсэн.

2020 оны 11-р сарын 11-ны өдөр УОК-ын Шуурхай штабаас хийсэн 14-р эрсдэлийн үнэлгээгээр КОВИД-19 халдвар тархах эрсдэл “ӨНДӨР” гэсэн дүгнэлт гарсан.

## **2. Дотооддоо КОВИД-19 халдварын тохиолдол бүртгэгдсэнээс хойш УОК-оос авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар:**

2020 оны 11-р сарын 11-ний өдрөөс үндэсний хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан УОК-оос дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна. Үүнд:

- 2020 оны 11-р сарын 11-17-ны өдрүүдэд Засгийн газрын тогтоол 2, Шадар сайдын тушаал 2, УОК-ын даргын тушаал 5, УОК-ын тогтоол 1, УОК-ын тэмдэглэл 3, УОК-ын даргын албан даалгавар 2-ыг тус тус гаргаж, салбар хоорондын уялдааг хангах чиглэлтэйгээр шуурхай арга хэмжээ зохион байгуулж байна.
- 2020 оны 11-р сарын 15-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрсдэлт нөхцөлд ажиллаж буй эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, цагдаагийн албан хаагчдад 10.142,620,000 төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн.
- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 18.1-ийн “Энэ хууль 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл үйлчилнэ” гэснийг “2021 оны 6-р сарын 30-ны өдрийг хүртэл” гэж өөрчлөх тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулан, УИХ-д өргөн барихаар Шадар сайдын ажлын албанаас бэлтгэж байна.
- Улаанбаатар хотоос орох, гарах зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 11-р сарын 12-ны өдрөөс эхлэн түр зогсоож, хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хүнсний ачаа тээврийн хэрэгслийг нарийвчилсан бүртгэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэм дор хот хоорондын хөдөлгөөнд оролцуулж байгаа болно. 11-р сарын 17-ны өдрийн байдлаар бүх аймгууд хот хоорондын хөдөлгөөнийг түр зогсоолоо.
- Улаанбаатар хотын нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг өглөө 07:00-10:00 цаг, орой 17:00-20:00 цагийн хооронд явах хуваарь гарган зорчигчдыг цагийн хязгаартайгаар тээвэрлэж байна.
- 2020 оны 11-р сарын 10-ны өдөр дотооддоо анхны тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан бүх захиалгат нислэгийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг цуцлах хүртэлх

хугацаанд үйлдэхгүй байх чиглэлийг УОК-оос Зам, тээврийн хөгжлийн яаманд өгсөн.

- Хот доторх олон нийтийн хөдөлгөөнийг хязгаарлах, олон хүн нэг доор бөөгнөрөхгүй байх зорилгоор төрийн байгууллагуудыг ажлын тусгай горимд шилжүүлж, ажлын байранд ажиллах албан хаагчдын тоог нийт бүрэлдэхүүний 10-15%-иас хэтрүүлэхгүй байх, бусад албан хаагчдыг гэрээсээ ажиллах боломжоор хангах чиглэл өгч ажиллаж байна.
- 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг нарт цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах боломжоор хангаж ажиллахыг байгууллагуудын удирдлагуудад чиглэл болгосон.
- Тусгаарлан ажиглах байрнаас гарсан иргэдийг гэрийн 14 хоногийн тусгаарлалт хийх шаардлагыг сэргэн хэрэгжүүлж байна.
- КОВИД-19 халдварын тохиолдлын тоо эрс нэмэгдэж, эрсдэлт нөхцөл байдал хурцадсан тохиолдолд Цэргийн төв эмнэлэгт 500 ор, Хан-Уул дүүрэг дэх Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 300 ор, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэгт 220 ор, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгт 225, ХӨСҮТ-д 400 (бэлэн 210, нэмж 190), **НИЙТ 1645** орыг дэлгэхээр бэлтгэл хангаж байна.
- Оношлуур, урвалж, эм эмнэлгийн хэрэгслийн 1 сарын нөөц байна.
- Сэлэнгэ аймаг руу Полимеразын гинжин урвал /PCR/ шинжилгээний 1 лаборатори нэмж нийт 2, Дархан-Уул, Ховд, Дорноговь, Дорнод аймгуудад тус бүр 1 лаборатори ажиллаж байна.
- УОК-ын даргын 2020 оны 22 дугаар тушаалаар Батлан хамгаалахын сайд, УОК-ын орлогч дарга Г.Сайханбаяраар ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдан, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн хэмжээнд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилт, мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, халдварын тархалтыг хяналтад авах, тандалт судалгаа хийх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэйгээр 2020 оны 11-р сарын 12-ны өдрөөс эхлэн ажиллаж байна.
- УОК-ын даргын 2020 оны 21 дүгээр тушаалаар Ерөнхий сайдын ахлах зөвлөх Ж.Энхбаяр Тусгай үүрэг гүйцэтгэгчээр томилогдон, 2020 оны 11-р сарын 13-ны өдрөөс Дархан-Уул аймагт цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх, зохион байгуулах зорилгоор Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийн хэрэгжилтийг хангуулах, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.
- УОК-ын даргын 2020 оны 25 дугаар тушаалаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтараар ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдан, “Улаанбаатар төмөр зам” ХНН-д үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан, төмөр замын салбарын гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлж, тандалт

судалгааг хийн, халдварын тархалтыг зогсоох, халдвар, хамгаалалтын дэглэмийг мөрдүүлж, холбогдох шийдвэрийг хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгтэйгээр 2020 оны 11-р сарын 17-ны өдрөөс эхлэн ажиллаж байна.

- Шадар сайдын 2020 оны 140-р тушаалаар Сангийн дэд сайд Д.Мөнгөнчимэгээр ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдан, “Алтанбулаг” боомтыг 2020 оны 11-р сарын 16-ны өдрөөс түр хааж байгаатай холбогдуулан боомт хаахаас өмнө Монгол Улсад орж ирж амжихгүй жолооч, тээврийн хэрэгсэл, бараа, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх чиглэлээр санал боловсруулахаар ажиллаж байна
- КОВИД-19 халдвартай гэж оношлогдон, ХӨСҮТ-д эмчлүүлээд эдгэрч гарсан иргэд болон тусгаарлан ажиглах байрнаас гарсан иргэдийн хяналтыг чангатган ажиллахыг нийслэл, аймгийн Онцгой комисст үүрэг өгч хэрэгжилтийг хангаж байна.
- УОК-ын дэргэд УОК-ын шуурхай хуралдааныг 2020 оны 11-р сарын 11-ний өдрөөс эхлэн өдөрт 2 удаа зохион байгуулж байна.
- Олон нийтэд үнэн зөв, бодит мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилгоор ЭМЯ дахь Шуурхай штабаас хэвлэлийн бага хурлыг өдөрт 2 удаа /11:00 цаг, 17:00 цаг/, УОК-ын хэвлэлийн бага хурлыг цаг үеийн асуудалтай холбогдуулан тухай бүрт Төрийн ордонд зохион байгуулж байгаа болно.

### **3. Тусгаарлах байрны талаар:**

Тусгаарлах байранд Онцгой байдлын байгууллагын 61, Цагдаагийн байгууллагын 187 алба хаагч, Эрүүл мэндийн байгууллагын 96 ажилтан, нийт 344 төрийн алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Улсын хэмжээнд 11 дүгээр сарын 16-ны өдрийн 22:00 цагийн байдлаар 41 тусгаарлан ажиглах байранд нийт **2,259** иргэн байна.( Үүнээс Монгол Улсын иргэн 1,921, гадаад улсын иргэн 338) Үүнд:

- Улаанбаатар хотод: Тусгаарлан ажиглах 25 байранд Монгол Улсын 1,525 иргэн, 7 байранд гадаад улсын 209 иргэн;
- Орон нутагт: Тусгаарлан ажиглах 10 байранд Монгол Улсын 396 иргэн, 4 байранд гадаад улсын 129 иргэн байна.

Улаанбаатар хотын Энхсаран сувилалд КОВИД-19-ын тохиолдол илэрсэнтэй холбогдуулан тус сувилалд байсан 66 иргэнийг “Дрийм”, 107 иргэнийг Кентавр” зочид буудал руу тус тус 11-р сарын 16-ны өдөр шилжүүлэн тусгаарласан.

- Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/513 дугаар тушаалаар байгуулагдан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Я.Амаржаргалаар ахлуулсан Ажлын хэсэг 2020 оны 11-р сарын 11-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хот дахь тусгаарлан ажиглах байруудад түргэвчилсэн хяналт, үнэлгээ хийж байна.

#### **4. Мэргэжлийн хяналтын арга хэмжээний талаар:**

##### **Нэг. Хилийн нэвтрэх цэгийн хяналт, тандалт**

2020 оны 11-р сарын 17-ны байдлаар улсын хилээр нэвтрэн орж ирсэн **348,332** тээврийн хэрэгсэл (онгоц **479**, вагон, зүтгүүр 6,967, суудлын машин 1,628, автобус 302, ачааны машин 338 956), **495,363** зорчигчдод (агаараар **57,908**, хуурай замаар **437,455**) эрүүл мэндийн хяналт хийж, **22,724** тохиолдлыг /**743** сэжигтэй болон **21,981** ажиглалтад авсан/ илрүүлж, ХӨСҮТ болон бусад аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, сувилалд шилжүүлсэн.

Халдварын сэжигтэй болон халуунтай байсан **97** гадаадын иргэнийг холбогдох байгууллагатай хамтран буцаасан.

ТИР ачаа болон жолооч нарын хяналт: 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд Алтанбулаг боомтоос 6,415 улс хоорондын тээврийн хэрэгслээр Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймгийн гүний хяналтын бүсэд ирсэн монгол **1964**, гадаад **4633**, нийт **6597** жолоочид эрүүл мэндийн хяналт хийж, **49** батлагдсан тохиолдол /**8** монгол, **41** гадаад/ илэрсэн, эдгэрсэн **25** жолооч, эмчлүүлж байгаа **17** жолооч, буцаасан **7** жолооч байна.

##### **Хоёр. Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажиллагаа**

Улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлд өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор нийт 48,068 объектын нийт 15,746,325 кв талбайд урьчилан сэргийлэх халдваргүйтгэл хийлгэж, хяналт тавьсан. Үүнд: нийтийн эзэмшлийн зам талбай, хүүхдийн тоглоомын талбайн 10 331 707 кв, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний газрын 6285 объектын 1 289 962 кв, орон сууцны барилга, байгууламжийн 1233 объектын 432340 кв, засвар үйлчилгээ, 2-догч түүхий эдийн цэгийн 808 объектын 183 933 кв, эрүүл мэндийн байгууллагын орчны 361 объектын 128 190 кв, малын хашаа, хороо, саравч болон эрчимжсэн аж ахуйн 10513 объектын 2 540 798 кв, нүхэн жорлон, бохирын цооног 27813 объектын 839 395 кв

Нийтийн тээврийн болон хот хооронд зорчиж буй 99,062 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, эрүүл ахуйн шаардлага хангахгүй 31,740 тээврийн хэрэгслийг цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийлгэн, үйлчилгээнд гаргасан.

Худалдаа, банк санхүүгийн болон бүх төрлийн үйлчилгээний байгууллагууд үйлчлүүлэгчдэд гар угаах нөхцөлийг бүрдүүлсэн эсэхэд давхардсан тоогоор 13760 /аймагт 8435, нийслэлд 5325/ байгууллагыг хамруулан хяналт хийхэд 11132 буюу 81 хувь /аймагт 6299 буюу 75%, нийслэлд 4933 буюу 93%/ нь гар угаах, бие засах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

*Хог хаягдлийн менежментийг сайжруулахаар ажиллаж байгаа бөгөөд олон улсын туршлагаас үзвэл ковидын хог хаягдлийг шатааж устгаж байна.*

#### **Гурав. Эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлын талаар:**

“Шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай” албан даалгаврын заалт бүрээр эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангуулж, дэмжлэгт хяналтыг тогтмол хийх ажлын хүрээнд улсын хэмжээнд 835 /аймгууд 744, нийслэлд 91/ эмнэлгийн бэлэн байдлыг шалгахад 129 /аймагт 112, нийслэлд 17/ эмнэлэгт бэлэн байдал хангагдаагүй байсан тул 69 байгууллагад 109 заалттай албан шаардлага, 34 байгууллагад 132 заалттай зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Төрөлжсөн мэргэжлийн болон төв эмнэлэг, дүүргийн Эрүүл мэндийн төвүүд, амаржих газрууд, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн 37.5 хувь нь болзошгүй халдварын үеийн бэлэн байдлыг хангуулахаар холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Харин хувийн хэвшлийн эмнэлгүүдийн 62.5 хувь, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөц хангалтгүй, болзошгүй халдварын үед авах арга хэмжээний бэлэн байдал болон амны хаалтны хүрэлцээ хангалтгүй байсан.

### **Дөрөв. Ахуйн болон бохир ус урьдчилан цэвэрлэх байгууламж, ундны усны эх үүсвэрт хийсэн хяналт шинжилгээ**

Улсын онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу аймаг, нийслэлийн ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ. Хяналт шалгалтад аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламж 35 хамрагдсан ба Туул голын тогтоосон 8 цэгээс дээж авч хими, нян судлалын шинжилгээнд хамруулан үнэлгээ дүгнэлт өгөв.

Хяналт шалтгалтаар илэрсэн зөрчлийг үндэслэн улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага 21, улсын /ахлах/ байцаагчийн зөвлөмж 5, шинжилгээний дүнд үндэслэн улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлт 28-ыг гарган, холбогдох газруудад өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир уснаас сар бүр, ХӨСҮТ-ийн урьдчилан цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир уснаас 7 хоног бүр хими, нян судлалын шинжилгээнд хамруулан үнэлгээ дүгнэлт өгч ажиллаж байна.

Нийслэл, аймаг, сумын ундны усны эх үүсвэрийн уснаас 1452, БААН, иргэний хувиараа гаргасан 396 худгийн ус нийт 1848 дээж авч нян судлалын шинжилгээнд хамруулахад 207 ба 11.2%-д ундны усны стандартын шаардлага хангахгүй гарсан байна. Туул голын 8 цэгээс авсан дээжинд хийсэн нян судлалын шинжилгээгээр Туул голын Уу булангийн хэсэгт маш цэвэр, Налайх, Баянзүрх, Зайсангийн гүүр орчим цэвэр, Сонсголон, Биокомбинат, Шувуу, Алтанбулагийн орчим их бохирдолттой ангилалд хамрагдаж байна.

### **5. Хилийн боомтууд, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний талаар:**

ОХУ-тай хиллэдэг Цагааннуур, Боршоо, Тэс зэрэг автозамын боомтуудын үйл ажиллагаа Засгийн газрын шийдвэрээр түр хугацаагаар, бүрэн зогссон. Мөн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг автозамын боомт 11 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэл бараа тээвэрлэсэн ачааны автомашиныг өндөржүүлсэн халдвар хамгааллын хяналт дор нэвтрүүлээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомтоор зөвхөн бараа, тээврийг нэвтрүүлэх горимоор ажиллаж байна. Дорнод аймгийн Эрээнцав төмөр замын боомтыг 2020 оны 11-р сарын 19-ны өдрөөс 12-р сарын 1-ны өдрийг хүртэлх хугацаанд хаах шийдвэрийг 11-р сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаас гаргав.

БНХАУ-тай хиллэж буй боомтууд, түүн дотроо уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспорт хийгдэж буй Гашуунсухайт, Шивээхүрэн, Замын-Үүд, Ховдын Булган, Хангимандал, Баянхошуу, Бичигт боомтуудын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. Говь-Алтайн Бургастайн боомт Алтай Хүдэр компанийн хүлээн авагч БНХАУ-ын компанитай төлбөр тооцооны маргааны улмаас төмрийн хүдэр экспортлогдохгүй байна.

Экспорт: Уул уурхайн ашигт малтмал, эрдэс бүтээгдэхүүний экспорт хэвийн үргэлжилж байгаа бөгөөд 2020 оны 11 сарын 12-16-ны өдрүүдэд өдөрт дунджаар **1,500–1,530** автомашин нүүрс, **96** машин зэсийн баяжмал, **13** машин төмрийн хүдрийг экспортолсон. Энэ нь оны эхнээс **25.9** сая тонн нүүрс, **1.2** сая тонн зэсийн баяжмал, **7.3** сая тонн төмрийн хүдэр экспортолсон байна.

*Гашуунсухайт ГГ:* БНХАУ-ын Ганц мод боомт нь 2020 оны 11 сарын 12-ны өдрөөс эхлэн задгай талбайд нүүрс буулгахгүй гэсэн шийдвэр гаргасан тул 3 аж ахуйн нэгж шинээр битүү агуулах барьж, нүүрс буулгалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

*Шивээхүрэн ГГ:* Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн өдрүүдэд хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо болон экспортлогдсон нүүрсний жингийн хэмжээг өмнөх өдөртэй харьцуулахад буураагүй гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Импорт: Импортоор орж ирж буй хүнсний бүтээгдэхүүн, эм, эмийн зүйлс, эмнэлэгийн хэрэгсэл, ариутгалын болон халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, бодис, түргэн муудаж гэмтэх, хадгалалт тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаардах барааны бүрдүүлэлтийг шуурхай зохион байгуулан ажиллалаа. Улаанбаатар хот дахь гаалийн газруудын бусад барааны импортын бүрдүүлэлтийг түр хугацаанд зогсоосон.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн эхний 5 хоногийн хугацаанд буюу 2020.11.12 – 2020.11.16-ний өдрүүдэд гол нэрийн бараа бүтээгдэхүүн болох автобензин, дизелийн түлш **29.4** мянган тонн, сүү сүүн бүтээгдэхүүн **26.6** мянган тонн, цагаан будаа **716.3** мянган тонн, жимс, хүнсний ногоо **1.7** сая тонныг тус тус импортолсон байна.

ОХУ-аас Сэлэнгэ аймгийн Алтанбулаг автозамын боомтоор 2020 оны 11 сарын 11-аас 16-ны өдрүүдэд нийт **250** тээврийн хэрэгслээр **3.8** мянган тонн ачаа орж ирснийг гаалийн хяналтанд авч, Сэлэнгэ, Улаанбаатар, Дархан, Орхон дахь гүний гаалийн газруудын гаалийн бүрдүүлэлтийг хийжээ.

## **6. Хүнсний хангамжийн талаар:**

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 21 дүгээр тушаалаар “Хүнсний хангамжийн удирдлагын шуурхай штаб”-ыг байгуулан мэргэжлийн байгууллагууд, яамны харъяа байгууллагуудтай цаг үеийн мэдээ, мэдээлэл солилцох, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, тулгамдаж буй арга хэмжээг шийдвэрлэн ажиллаж байна.

Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлыг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулан дараах асуудлуудыг шийдвэрлэв. Үүнд:

- Зарим бүтээгдэхүүний гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, УИХ-д өргөн барихаар шийдвэрлэв.
- 2020 онд нэмэлтээр экспортлох адууны 15.0 мянган тн мах, импортлох 40.0 мянган тн үрийн улаан буудай, 150.0 мянган тн хүнсний улаан буудайн тоо хэмжээг тогтоолоо.
- Хүнсний нөөц, аюулгүй байдалтай холбоотойгоор зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн болох шар, цагаан будаа, ургамлын тос, өвс тэжээлийг Гаалийн татвар, НӨАТ-аас чөлөөлөх асуудлыг дэмжиж, УИХ-д өргөн барихаар шийдвэрлүүлээ.
- Гурилын үйлдвэрүүдэд 100.0 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор тогтов. Үүнтэй холбогдуулан хэрхэн шуурхай олгох талаар холбогдох мэдээллийг Сангийн яам, Хөгжлийн банкуудад хүргүүлж 150.0 мянган тн улаан буудайн нөөцийг бүрдүүлэхээр 100 тэрбум нөөцийн зээлийн эх үүсвэрийг Хөгжлийн банкнаас гаргахаар шийдвэрлэв.

Монгол Улсын Шадар сайд, УОК-ийн даргын тушаалаар байгуулсан Хүнсний хангамжийн удирдлагын шуурхай штабын ХХААХҮЯ-ны ажлын баг хүнсний дотоодын тээвэрлэлт, олон улсын тээвэрлэлт, хүнс импортлогчдын гадаад төлбөр тооцоо хийх боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Мөн аймгуудад махны нөөцийн чиглэлээр хүмүүстээ халдвар хамгааллын дэглэмээ сайтар баримтлан явах, хүнс тээвэрлэж байгаа нэрээр маршрут зөрчихгүй байх, жолоочийн кабинд зорчигч тээвэрлэхгүй байх, голомттой бүс нутгаар нэвтрэхдээ машинаас буухгүйгээр зөвхөн бараагаа өгөөд буцах талаар ЭМГ-тайгаа хамтран зөвлөмж өгөх, хотруу махтай ирж, буцахдаа ахуйн бараа болон гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг ачиж явахад анхаарах зэрэг зөвлөмжийг хүргүүлж ажиллаа.

Аймаг, нийслэлээс 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр авсан судалгаагаар улсын хэмжээнд 11.9 мянган тн малын мах, 108.6 мянган тн гурил, 1.4 мянган тн гурилан бүтээгдэхүүн, 7.9 мянган тн төрөл бүрийн будаа, 1.8 мянган тн хуурай сүү, 1.2 сая ширхэг өндөг, 1.1 мянган тн ургамлын тос, 97.1 мянган тн төмс, 39.5 мянган тн хүнсний ногоо, 4.1 мянган тн элсэн чихрийн нөөцийн үлдэгдэлтэй байна. Энэ судалгаанд Улаанбаатар хот, хөдөө орон нутгийн худалдааны зах, төв, дэлгүүрүүд, хүнсний үйлдвэрүүд дэх хүнсний



нөөцийн үлдэгдлийг тооцсон. Харин нийслэл, орон нутгийн мухлаг, жижиг дэлгүүр, айл өрхийн хэрэгцээнд хадгалсан нөөц, мөн хөдөө орон нутгийн төмс, хүнсний ногооны жижиг зoorь, агуулахын нөөц ороогүй болно.

Нийслэлийн хүн амын махны хэрэгцээг хангах, махны үнийг тогтвортой байлгах зорилгоор 2020 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн нөөцийн махны худалдааг зохион байгуулж эхэлсэн. Махны эрэлт их байгаа тул нөөцийн мах худалдаалах цэгийн тоог нэмэгдүүлж, өнөөдрийн байдлаар аж ахуйн нэгжүүд үйлдвэрээс татах махны нийлүүлэлтийг 2-3 удаа хийж, Нийслэлийн зургаан дүүргийн 22 байршилд, 14 аж ахуйн нэгжээс 4 өдрийн байдлаар нийт 223 тн хонины махыг гулууз хэлбэрээр худалдан борлуулсан.

ОХУ-аас 150 мянган тонн хүнсний улаанбуудай, 40 мянган тонн үрийн улаанбуудайн худалдан авахаар урьдчилсан үнийн хэлцэл хийж байгаа бөгөөд нийтдээ 150.0 тэрбум төгрөг шаардагдах тооцоог хийн эх үүсвэрийг шийдвэрлэх чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллаж байна.

Хөдөө аж ахуйг дэмжих сангийн агуулахад нийт 4,170.74 тн үрийн улаанбуудай, 25,332.42 тн хүнсний улаанбуудай нөөцлөгдсөн бол аж ахуйн нэгжүүдэд 20.0 мянга гаруй тн үрийн улаан буудай нөөцөлсөн байна.

Хүнсний нөөцийн мэдээллийг аймаг, нийслэлээс 7 хоног бүр 2 удаа авч байна. 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн судалгаагаар улсын хэмжээнд 11.9 мянган тн малын мах буюу 37 хоногийн, 108.6 мянган тн гурил буюу 176 хоногийн, 7.9 мянган тн төрөл бүрийн будаа буюу 60 хоногийн, 1.8 мянган тн хуурай сүү буюу 37 хоногийн, 1.1 мянган тн ургамлын тос буюу 18 хоногийн, 97.1 мянган тн төмс буюу 305 хоногийн, 39.5 мянган тн хүнсний ногоо буюу 57 хоногийн, 4.1 мянган тн элсэн чихэр буюу 47 хоногийн нөөцийн үлдэгдэлтэй байна.

### **7. КОВИД-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бусад арга хэмжээний талаар:**

2020 оны 11-р сарын 17-ны өдрийн байдлаар КОВИД-19 халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах асуудлыг Засгийн газрын хурлаар 24 удаа, Улсын онцгой комиссын хурлаар 35 удаа, УИХ-ын нэгдсэн чуулганд 2 удаа, УИХ-ын Байнгын хороонд 2 удаа, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 4 удаа, УИХ-ын Түр хороогоор 1 удаа тус тус хэлэлцүүлэн, холбогдох шийдвэрүүдийг гаргуулж, Улсын онцгой комиссоос хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Мөн УИХ-аас баталсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Эрүүл мэндийн яамнаас чиглэл болгож буй КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх бодлогын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ салбар хоорондын болон байгууллага хоорондын уялдааг сайжруулах, Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлагдсан “КОВИД-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх стратеги, төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг тухай бүрт нь

үүсээд байгаа болон үүсэж болох нөхцөл байдалтай нягт уялдуулан шуурхай хариу арга хэмжээ авах зорилгоор КОВИД-19 халдварын цар тахлын үеийн Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны Шуурхай штабыг УОК-ын Шуурхай штабтай нэгтгэн, Эрүүл мэндийн яам дээр төвлөрүүлэн ажиллаж байна.

Шадар сайдын 2020 оны 89 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгээс КОВИД-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх үед төв, аймаг, нийслэл, дүүргийн Шуурхай штабын үйл ажиллагааг чиглүүлэх сургалтууд зохион байгуулагдаж байна.

КОВИД-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор 2020 оны улсын төсвийн тодотголд Гадаад харилцааны яам, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газарт шаардлагатай “Хөдөлмөр хамгаалал, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, уусмал, тоног төхөөрөмж”-өөр хангахад 7.7 тэрбум, “Цар тахлын үед эрсдэлтэй бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад олгох урамшуулал, цалин, илүү цагийн хөлс”-д 2.3 тэрбум, эмнэлгийн багаж хэрэгсэлд 118.0 тэрбум, нийт 128.0 тэрбум төгрөгийг тусгасан.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд салбар хоорондын ажлын уялдаа холбоог хангах, олон эх үүсвэрт мэдээлэл шинжилгээний **burtgel.mohs.mn** системийг хөгжүүлэх ажлыг Эрүүл мэндийн яам, УОК-ын Шуурхай штаб дээр хийж байна.

Шинэ коронавируст цар тархлын улмаас хилээр зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрээр гадаадад гацсан монгол иргэдийг татан авах ажиллагааг шат дараатайгаар тасралтгүй зохион байгуулж байна.

Улсын онцгой комиссын шийдвэрээр 2020 оны 1 дүгээр сарын 28-аас 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар дэлхийн 91 улсаас 27,184 иргэнийг татан аваад байна. Үүнээс 106 удаагийн захиалгат нислэгээр – 20582, (ОХУ-аас 2392, БНХАУ-аас 4210) иргэнийг тус тус эх оронд нь авчраад байна. Сүүлийн саруудад захиалгат нислэгийн чиглэл, давтамжийг тогтмол нэмэгдүүлж байгаа болно.

КОВИД-19 халдварын тархалтаас хамгаалах чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаад улс орны, олон улсын болон донор байгууллагуудын үйл ажиллагааг Засгийн газраас баримталж буй бодлоготой уялдуулах зорилгоор Монгол Улсын Шадар сайд, НҮБ-ын Суурин зохицуулагчтай хамтран удирдах “Нэгдсэн зохицуулалтын бүлэг”-ийг ажиллуулж байна. Ингэснээр бүх олон улсын тусламж, хандивын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, манай улсын КОВИД-19 халдвараас хамгаалах хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн олон улсын түнш байгууллагуудын нөөц боломжийг нэгдмэл байдлаар дайчлан хуваарилах, хамтын ажиллагааны уялдааг сайжруулах боломжуудыг бүрдүүлэн ажиллаж байна.

Шадар сайдын Засгийн газар, Улсын онцгой комисс болон бусад холбогдох байгууллагын шийдвэрийн эрх зүйн чадамж болон хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, хууль эрх зүйн зохицуулалтын хувьд нэмэлт өөрчлөлт хийх санал, дүгнэлт боловсруулах шаардлагатай гэж үзэн Шадар сайдын тушаалаар Улсын онцгой комиссын гишүүн байгууллагууд, Хүний эрхийн үндэсний комисс, Жендерийн үндэсний хороо, Үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдаж 9-10-р саруудад ажилласан.

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 99 дүгээр тушаалаар Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Улсын онцгой комиссын Шуурхай штабаас гаргасан холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиар яам, агентлаг, аймаг, нийслэл, төрийн байгууллагуудад үүрэг, даалгавар болгосон 50 заалт, УИХ-ын 2 тогтоолын 25 заалт, Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 3 заалт, Засгийн газрын 21 тогтоолын 69 заалтын хэрэгжилтийг 2020 оны 3 дугаар улирлын байдлаар нэгтгэн үнэлгээ хийж, дараах дүгнэлтийг гаргав:

- Үүрэг, даалгавар болгосон хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн биелэлтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу нийт 68 шийдвэрийн 436 заалтыг хяналтад авч үнэлгээ хийж, нэгтгэн дүгнэснээс “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль” **90.0** хувьтай, УИХ-ын тогтоол **94.83** хувьтай, Ерөнхийлөгчийн зарлиг **88.0** хувьтай, Засгийн газрын тогтоол **96.92** хувьтай, УОК-ийн шийдвэрийн нэгдсэн дүн **94.7** хувьтай байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нийт дүн 2020 оны 3 дугаар улирлын байдлаар **95.0** хувьтай байна.
- Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, зорилгоор хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг яамд 92.68 хувьтай, агентлагууд 96.1 хувьтай, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар 97 хувьтай, УОК 94.7 хэрэгжүүлсэн байна.

**8. КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэхэд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас УОК-т өгсөн хандив, тусламжийн талаар:**

КОВИД-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжиж 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар Улсын Онцгой комисст 291 аж ахуйн нэгж, байгууллага, 257 иргэнээс нийт 3.5 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгө, 121 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс 4.3 тэрбум төгрөгийн өртөг бүхий бараа материал, нийт 7.8 тэрбум төгрөг хандивлаж, 6.6 тэрбум төгрөгийг Улсын онцгой комиссын шуурхай штаб, төрийн байгууллагууд, нийслэлийн автозамын шалган нэвтрүүлэх товчоо, хяналтын цэг, тусгаарлах байрны хэрэгцээнд болон шаардлагатай тоног төхөөрөмж, үйл ажиллагаанд зарцуулаад байна.

**9.КОВИД-19 халдварын цар тахлын дэглэлтийг хязгаарлан, зогсоох чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:**

УОК-оос халдварын дотоод дахь тархалтыг хязгаарлан зогсоох чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

**1. Хуульд өөрчлөлт оруулах чиглэлээр:**

А. “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 18.2-т “Энэ хуулийн 18.1-д заасан хугацааг Монгол Улсын Их Хурал зургаа хүртэл сараар нэг удаа сунгаж болно.” гэж заасны дагуу хуулийн үйлчлэх хугацааг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгах хуулийн төслийг УИХ-д өргөн барих бэлтгэлийг ханган ажиллаж байгаа тул УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

Б. Хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зарим бүтээгдэхүүний гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж УИХ-д өргөн барихаар хүргүүлсэн байгааг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах.

**2.КОВИД-19 халдварын эсрэг вакцин нийлүүлэх чиглэлээр:**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр өнөөдөр нийт **202 вакцины** судалгаа хөгжүүлэлтийг идэвхитэй хийж байгаагийн **47 нь эмнэл зүйн туршилтад**, 155 вакцин эмнэл зүйн өмнөх буюу амьтны бие дээр турших шатандаа байна. Эмнэл зүйн туршилт, судалгааны **3-р үе шатанд 10** вакцин байгаа. Үүнээс БНХАУ- 4, АНУ- 4, ОХУ- 1, Их Британи /Оксфордын их сургууль+Астра Зенека/ -1 вакцин тус тус хөгжүүлж байна.

Вакцин дархлаажуулалтын глобаль альянс /ГАВИ/, ДЭМБ, Дэлхийн банк, Европын холбоо болон бусад олон олон улсын байгууллагуудын хамтран байгуулсан КОВАКС механизм /COVAX Facility/ нь КОВИД-19 халдварын эсрэг вакцины хөгжүүлэлтийг дэмжих, үйлдвэрлэсэн вакцины хүртээмжийг улс орнуудын хэрэгцээнд нийцүүлэн тэгш байдлаар бий болгох зорилготойгоор ажиллаж байгаа бөгөөд манай Засгийн газар 2020 оны 7 дугаар сарын 16-ны өдөр албан ёсоор уг механизмд нэгдэн орох хүсэлтээ хүргүүлж нэгдсэн. Энэ механизмын хүрээнд тухайн орны нийт хүн амын 20 хүртлэх хувийг вакцинжуулалтад хамруулах тооны вакциныг үнэ төлбөргүй олгоно. Нэмэлтээр хүн амын 40 хувийг хамрах тооны вакциныг уг механизмын хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр худалдан авахаар төлөвлөж байна.

Энэ худалдан авалтыг COVAX Facility механизмын хүрээнд хийхийн гол ач холбогдол нь:

1. Худалдан авах вакцин гагцхүү ДЭМБ-ын чанар, аюулгүй байдлын гэрчилгээтэй байна.
2. Үнэ өртөг нь КОВАКС-ийн үнээр байх тул олон улсын зах зээлийн хөөрөгдсөн үнээс зайлсхийнэ.

ЭМЯ-наас вакциныг тээвэрлэн авчирах, түгээх, хийх үндэсний төлөвлөгөөг 2020 оны 7 дугаар сараас боловсруулж эхэлсэн бөгөөд нэг хүнд ноогдох тун, хоногийн зай зэрэг мэдээлэл ДЭМБ-аас энэ оны 11 дүгээр сараас л тодорхой болж байгаа ямар төрлийн вакциныг худалдаж авахаа эцэслэн шийдвэрлэсэнээр уг төлөвлөгөөг Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлуулах бэлтгэл ажил үндсэндээ хангагдсан байгаа.

Монгол Улсын Засгийн газар Дэлхийн банкнаас вакцин худалдан авах зориулалтаар 50,7 сая ам.долларын зээл авахаар хэлэлцээ хийж байгаа.

Вакцин дархлаажуулалтын глобаль альянс болон КОВАКС механизмд эцэслэсэн хүн тун, вакцины технологийн сонголт хийсэн хүсэлтээ Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын гарын үсэгтэйгээр 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрөөс өмнө илгээх шаардлагатай тул уг хүсэлтийг 12 дугаар сарын 1-ний өдөр илгээхээр ажиллаж байна.

## **2.КОВИД-19 халдвартай тэмцэх, хариу арга хэмжээ авах”** **төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар:**

Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “КОВИД-19 халдварын цар тархалтын үеийн Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шуурхай хариу арга хэмжээ авах” төлөвлөгөө”-г хэрэгжүүлэн ажиллахдаа дараах үйл ажиллагааг зохион байгуулна.Үүнд:

-Нийслэл, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын зочид буудал, барилга, байгууламжийг тусгаарлан ажиглах байрны зориулалтаар дайчлах;

- Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун зэрэг стратегийн бүтээгдэхүүнийг бодит нөөцөд тулгуурлан 1 хүнд ногдох тоо хэмжээгээр олгох, түгээх;

- Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хуваарилах, олгох ажлыг зохион байгуулах хүмүүнлэгийн кластерийн багийг ажиллуулах;

- Халдвар голомтлон бүртгэгдсэн хүн амыг коронавирусын халдварыг илрүүлэх шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах;

- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг ажлын тусгай горимд шилжүүлэх;

- Нийтийн тээврийн хөдөлгөөнийг зогсоож, авто тээврийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд орох, гарах хөдөлгөөнийг бүрэн хаах;

- Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг улсын хэмжээнд эрчимжүүлэх;
- ДЭМБ-аас баталгаажуулсан коронавирусын эсрэг вакциныг захиалж, үйлдвэрлэгчтэй шууд хэлэлцээ хийж худалдан авалт хийх;

## УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС